



ЦӨЛӨӨР

ЖОН БРАУН



# АЯЛСАН НЬ







# ЦӨЛӨӨР Жон Браун АЯЛСАН НЬ



Улаанбаатар хот  
2007 он





# Гарчиг

- Хутганы ирэн дээрх амьдрал 4  
Авч явах хэрэгслүүд 6  
Аяллын газрын зураг 8  
Тэнгэр баганадсан ёндөр барилгуудаас аварга том кактус хүртэл 10  
Оддын доорх гэр орон 12  
Өндөгний “аяга”-н дахь гэр бүл 14  
“Хаздаг” ургамлууд 16  
Улайссан хилэнцэт хорхой ба хоржигнуур мөгий 18  
Өөр нэг өртөнцөөр аялсан нь 20  
Цэлийн галын наадам 22  
Өнгө өнгийн хивс 24  
Өргөсгүй гайхлууд 26  
Цэлийн манаач 28  
Эвэртэй гүрвэл ба ургац хураагч шоргоолж 30  
Хурлан гүйгч ба тэнгэрийн чононууд 32  
“Мангас”-тай тааралдсан нь 34  
Бахны хайр дурлал ба харваж буй одод 36  
Гранд канёон 38  
Цэлийн хүмүүс 40  
Аюулд өргөж буй цэл 42  
Цэлийг хамгаалах нь 44  
Үгийн тайлбар 46  
Индекс 48

*Хутганы ирэн дээрх*


## Амьдрал

Цэл бол эрс тэс уур амьсгалтай газар. Өдөр нь хад чулуу өндөг шарж болмоор их халж, харин шөнө нь хелдтэлээ хердэг. Жилийн ихэнх одруудд цэлд маш их хуурай, тун цөөхөн өдөр бороотой байдаг төдийгүй зарим жилд нь ер бороо ордогтүй. Жилийн турш ордог нийт бороо нь л гээд аяга ч дүүргэхээргүй очуухэн бага байдаг.

► Сонораны цэлд маш олон янзын ургамал байгалийн хатуу ширүүн нехцэлд ургаж байна.

Цэл дэлхийн излээд олон хэсэгт байдаг. Хамгийн том нь Хойд Африкт орших Сахарын цэл бөгөөд АНУ-ийн нутаг дэвсгэртэй тэнцхүүц том газар нутаг юм. Хамгийн хуурай нь Өмнөд Африкийн Атакама цэл бөгөөд энэ нутгийн зарим хэсэгт хэдэн зуун жилээр ч бороо орохгүй тохиолдол бий. Бид цолийг хэднэ бээр үргэлжилсэн элсэн манхнуудаар тосоёлдэг ч цэлүүд нь янз бүр байдаг. Зарим цэлүүд хадтай уултай байхад зарим нь тэгш, ямар ч ялгарч харагдах юмгуй байдаг.

► Цэл бүхэн халуун байдаггүй. Хойд месөн далайн зарим хэсэг нь маш хуурай байдаг ба маш цөөхөн тооны амьтад амьдардаг.



Цэл тэр чигээрээ элсээр бүрхэгдсэн байдаггүй. Тэнд олон төрлийн амьтан ургамал байдаг. Гэвч заримдаа тэднийг олж хараад тун бэрх. Целийн амьтан ургамлууд байгалийн хатуу ширүүн нехцэлд дасан зохицох чадвартай байдаг бөгөөд тэд амьдрахын тулд маш олон ухаалаг арга замуудыг олсон байдаг.

▲ Оман улсад орших Эзгүй Тив: хүмүүст байдаг целийн талаарх нийтлэг төсөөллийн адилар олон мянган бээр үргэлжлэх элсэн манхнууд энд оршино.



Хүмүүс цөлд амьдрахад туйлын бэрх юм. Хэрэвээ сүүдээрт орохгүй л бол маш хүчтэй нар бидний арьсыг түлиэ. Халуунд хүний хөлс гарч сэргүүцдэг. Энэ нь бидний бие маш их хэмжээний усаа алдаж байна гэсэн үг. Сүүдээрт суусан ч гэсэн, едөрт 2-3 том аяга ус уух шаардлагатай болдог.



▲Атакамагийн целийн ургамалууд далайн мананд агуулагдаж буй усаар ундаалан ургадаг.

Бидний аялах цөл бол Сонораны цөл юм. Энэ цөл АНУ-ийн баруун өмнөд болон Мексикийн хойд хэсгийн томоохон хэмжээний газар нутгийг эзлэн оршино.

Авч явах

## Хэрэгслүүд

Цол хэдийгээр үзсгэлэнтэй ч зарим талаараа аюултай. Тиймээс бид аяллаа маш сайн төвлөвлөж, тохирох тоног хэрэгслүүдээ авч явах хэрэгтэй.



▲ Энэхүү овермоц хийцтэй цвэршуулэгчийг нь ус ух шаардлагатай үедээ усаа цвэр болгоход хэрэглэгдэнэ. Цөлийн аялалд хэрэг болох хамгийн чухал зүйл бол ус юм.

Тусламж авах бололцоогүй газарт буудалласан тохиолдолд ямар нэгэн зүйл буруугаар эргэвэл амь гарахад хангалттай хүрэлцхүйц устай байх ёстой. Бидний ачааны машинд дервэн том савтай ус байгаа. Мен жижиг цвэршуулэгч байна. Тиймээс хэрээ бидний ус дуусаад ууж болохуйц усны ямар нэг эх үүсвэртэй таарвал бид түүнийгээ хэрэглэж болно гэсэн уг. Зарим тохиолдолд сүүдэргэй газар борооноос үлдсэн шалбаагны ус тогтсон байдал. Гэвч тэр усыг зайлшигүй цвэрлэж байж хэрэглэх ёстой.



▲ Бид аяны гал тогооны амин чухал хэсэг болох энэ бляцкан зуухан дээр хоол ундаа чанана.

Бид жижигхэн зуух болон талх, хатаасан жимс, будаа, гоймон зэрэг зарим иргэний хүнсүүдийг авч явна. Харин хөргөгчинд хадгалах шаардлагатай хүнс авч явахгүй. Учир нь цэлд тэдгээрийг сэргүүн байлгах ямар ч боломж байхгүй.

Анхны тусламжийн савандaa кактусны өргөсийг авахад зориулсан хямсаа маягийн юм, мөн их алхсанаас болж цвэрүү үүсвэрл наах наалт авч хийнэ. Хүн бүр гар чийдэн, нөөц батерей авах ба цэлд юу ч тааралдаж магадгүй тул дуран, зургийн аппарат авах хэрэгтэй.

► Гэр аль зүйт байна вэ? Бид плүүжингийн тусламжтайгаар майхан уруугаа буцаж очих замаа олно.



Бид хөнгөн хувцас, нарнаас хамгаалах том саравчтай малгай болон нарны тос ихийг авч явах хэрэгтэй. Шенедеө хүйтэн болох тул аяны хөнжил, ноосон цамц авч явна. Цэлд алхаад кактусны ергөс хөл үрүү хатгадаг тул хатуу ултай, сайн чанарын гутал өмсөж явах нь чухал.

Зургийн аппарат:

Зураг авахад тохиромжтой хамгийн сайхан цаг нь өглиө зрт болон үдийн хойно юм. Цэл бол маш үзэсгэлэнтэй учир зургийн аппарат авч явах хэрэгтэй.

Аяны үүргэвч: Өөртөө таарсан, үүрэхдээ звтэйхэн үүргэвч авч явах нь зүйтэй. Үүргэвчиндээ юмаа хийхдээ эн түрүүнд хэрэг болох эд зүйлсээ хамгийн дээр нь хийгээрэй. Тэгвэл авахад амар шүү дээ.



Усныхаяа савыг үүргэвчинийхээ гадна талд байрлуулбал уух юм чинь гарын дор байна гэсэн үг.



Малгай: Толгойгоо хүрц нарнаас хамгаалахад том саравчтай малгай өмсөх нь маш чухал.

Дуран: Иймэрхүү адал явдалд хоёр нүдний сайн дуран зайлшгүй хэрэгтэй байdag. Цэлд юу ч харагдахыг хэн байг гэхэв.

Хувцас: Бүдэг өнгөтэй хувцас өмсөх нь хамгийн зөв. Учир нь хувцас чинь целийн өнгөтэй хосолж, түүнчлэн зэрлэг амьтантай таарвал чи түрүүлж түүнийг харах болно.

Машиндаа хоёр ширхэг илүү дугуй, дээр нь хагарч болзошгүй гэж үзээд дахиад хэдийг авах хэрэгтэй. Элсэнд суувал ухах хурз авна. Мөн хаашаа явах, хэзээ ирэхэ сайтар нарийвчлан бичсэн тэмдэглэлийг найзууддаа үлдээх нь зөв. Хэрэвээ билээд бөрхшээл тохиолдвол тэд билднийг аварч чадах боломжтой болно.

Гутал: Хаданд авирахад тохиромжтой, кактусны ергеснөөс хамгаалах аргар ултай байх хэрэгтэй.

# Аяллын газрын зураг

**С**онорыны цэл нь 250000 км<sup>2</sup> талбайг эзлэн оршдог. Цэлийн төрх байдал нь янз бүр. Зарим газар нь хэдхэн бутлаг ургамал бүхий тэгш тал байхад бусад хэсэг нь өтгөн ургамал бүхий хавцлууд байх жишээтэй.

Цэлийн том том хэсгүүд маш хол орших бөгөөд ихэнх хүмүүс очиж чадлагатгүй. Харин зарим газраар унаа машин холхисон замууд сүлжилдэх агаад байшин, ферм хаа сайгүй үзэгдэнэ.

Бид энэхүү аяллаараа жинхэнэ онгон зэлгүүд цэлийг харахыг хүсч байгаа учир цэлийн төв хэсэгт буудаллахаар хотоосоо илзээд хол явах шаардлагатай байлаа. Бид нэг газар хэд хоноод, тухайн газартайгаа танилцахын тулд хэд хэдэн жижиг аялалд явганаар явахаар төловлеөд байна. Явганаар явах нь илүү сайхан байдаг. Учир нь бид амьтдыг харах боломж илүү болж, цэлд яваагаа илүү ихээр мэдрэх болно.

Харин замдаа бид замаасаа хазайж Гранд Канён (Их Хавцал), Америкийн индианчуудын зарим нэг балгасыг үзэх болно.





Тэнгэр Баганадсан өндөр Барилгуудаас

# Аварга Том Кектус

## Хүртэл

**Б**ид цөл үрүүгээ түрж орсон, сүндэрлэсэн олон өндөр барилгуудтай Хойд Америкийн нэгэн том хотод ирлээ. Ачаа тээшээ аваад, хамт явах найзуудтайгаа уулзлаа. Онгочны буудлын хаалгаар гартал, нарны гэрэл төөнөж, халуун агаар өөдөөс дүүгэв. Яг л томоохон гэгчийн зуух уруу орж байгаа мэт байлаа. Би урьд нь хэзээ ч ийм халуун газарт байж үзээгүй билээ.

► Сонораны цөл уг хотын баруун захаас эхэлнэ. Бид даруй хотоос баруун тийш гардаг замыг олон хеделлэв.


Бүх ачаа тээшээ машинд ачаад, адал явдлаа эхлүүлэхээр хотоос гарлаа. Хүн машин холхисон хотын гудамжууд ард хоцорч, аль хэдийн цэлд хэл тавьснаа олж харав. Урт зам бидний урд зурайна. Эхэндээ зам бартаагүй байсан тул явахад тун амар байсан ч, хотоос холдох тусам зам улам бүр донсолгоотой болж байлаа. Бидний машин дервэн дугуйтай, хүчтэй сайн машин байсан тулдаа элстэй голын голдрилуудыг онгорч, эгэх хадтай зам уруу авирч гарч байлаа. Замын донсолгоо ихсхүү тусам хурдаа хасч, ямар нэгэн зүйлээс чангажаа барьж явах шаардлагатай боллоо. Яг л тоглоомын талбай дээр галзуу хулганад сууж байгаа мэт санагдаж байв.

► Бид их хотыг орхин, урт удаан аяллдадаа гарлаа. Урт зам хөндлөн гулд зуурайн, яг л бидний адал явдал эхэлсэн юм шиг санагдаж билээ.

Хэчинээн зузаан дугуй байсан ч хүрц шовх хад чулуунд хагарч магадгүй байлаа. Гэтэл дугуй маань хагарч, бид зогсов. Дугуйг солиход хэдхэн минут шаардагддаг. Гэтэл аль хэдийн бидний хөлс асгарчихсан байв. Би эрэг чангалах түлхүүрээ хүрц нар төөнөсөн газар дээр тавьчахв. Том алдаа боллоо! Би түлхүүрээ авах гэтэл хүрэхийн аргагүй халуун болчихсон байв.

Тэгээд би гарваа даавуутаар ороож байж нэг юм түлхүүрээ аван, багажныхаа саванд хийсэн юм.

Гурван цагийн турши явсаны дараа, хот сая бээрийн тэртээ хоцорлоо. Эргэн тойронд ганц ч хүн харагдахгүй байлаа. Замдаа ядарсан бил буудаллах газраа хайлаа.



► Явах тусам зам улам бартаатай болж байлаа. Бид байнга н ачаа тээшээ шалгаж, зам дээр ямар нэгэн зүйл хаягдсан эсэхийг харж явлаа.



# Оддын Доорх Гэр Орон

**Б**удаллахад тохиромжтой газрыг олох нь маш чухал байдаг. Бид майхан барихад амар, тэгүү, аятайхан газар хайж байлаа. Гэхдээ ширгэсэн гол байж болохгүй. Учир нь ширүүн бороо орвол ус урсан ирж, биднийг урстаж ч магадгүй.

Бид майхныхаа орчмоор явах болон майхнаа барих үедээ ямар ч жижиг ургамал ногоог гишгэлэхийг хүснэгтүү. Тиймээс нүүцэн хад юм уу злэсэн дээр майхнаа барих нь зөв. Буудаллах газраа сонгоходоо биднийг явсны дараа энд хүн байсан гэсэн ямар ч ул мөр үлдээх ёсгүй санах хэрэгтэй. Бид авчирсан бүх зүйлээ засач төвхөнөлөө. Ингэхдээ майхны орчинд байгаа ургамал, хад чулууг гэмтэхгүйн тулд болгоомжтой байх хэрэгтэй билээ. Энэ нь целийг хамгаалахад нэмэр болох бөгөөд, дараа энд ямар нэгэн хүн амьттан ирвэл бидний адил зэрлэг онгон, шинэ бүхнийг мэдрэх болно гэсэн ёт.

Бид Сагуаро кактус, пало вера модоор хүрээлгэсэн нэгэн сайхан газрыг олж аваад модны сүүдэрт нь машнинаас тавилаа. Халуун машнинаас бууж,

хөлөө

тэнийлгэх унхээр сайхан байлаа. Машнины дуу зогссоны дараа цэл бур нам гүм байсан бөгөөд алсад зөвлөн салхины чимээ, шувуудын жиргээ л сонсогдож байгаа нь үнэхээр гайхалтай санагдаж байв. Бид машнинаасаа ачаа тээшийн буулган задалж, хувцас хэрэгслээ хийх жижиг майхан барихаар хоёр модны дунд бүтээлгээ уялаа.

▼ Майхнаа хурдан барьж дуусгалаа. Ингээд бидний цэл дэх гэр бэлэн боллоо.

Бид өөр өөрдийн майхнаа зохи газраа сонгож авав. Аяллаар явахад майхан маш их хэрэгтэй байдаг.

Майхан бол өдрийн халуунд сэргүүн сүүдэр гаргаж, зуны гэнэтгийн бороо шуурганаас хамгаалдаг. Гэхдээ целийн алалмын хамгийн сайхан зүүлүүдийн нэг нь оддын дор гадаа унтах юм. Бид майхныхаа гадаа нүүцэн газар дээр гудсаа дэвслээ.



Хэрэгт дуртай газрын хэрэм биднийг харахаар ойролцох кактусны орой уруу авиралаа. Түүнийг шинэхэн хөршүүдээ таатайхаа хүлээн авна гэж би бодоогүй билээ. Хэрэм шуухалсан авна гаргасаар дэгдэн алга боллоо. Бид ойролцоо хад чулуун доогуур шагайн, хилэнцүйт хорхой, могой зэрэг байгаа эсэхийг шалган, шоргоотжны үүрэнд ойрхон байх вий хэмээн илтээд сайн харлаа. Майхнадаа ямар нэгэн урилгагүй зочин оруулмааргүй л байна шүү!

◀ Хөршүүтэйгээ уулсан нь: Биднийг майхнаа зохи байхад негеэ газрын хэрэм хажуутгийн кактусан дээрээс харж байлаа.

► Хүн машин холхисон хотоос хол орших целийн энэ хэсэг магадгүй хэдэн миньгэн жилийн турш өөрчлөгдөвгүй л болов уу. Энд аварга том сагуарогийн янзаараа газар хэвтэж байгаа улдгүйдлийг харж болно.





Өндөгний “Аяга”-н Дахь

## Гэр Бүл

**Б**ид майхнаа засчхаад эргэн тойрноо сонирхоо ойрхон алхлаа. Бидний ирсэн цэл үнэхээр онцгой байлаа. Зун нь +500С-ийн халуун, өвөл нь цас ороход хангалттай их хүйтэдэг байна. Кактусан дээр цас байгааг харна гэдэг үнэхээр хачирхалтай шүү.

Зарим жилд энд бороо орлоггүй бөгөөд уг цэл яг үхчихсэн, наранд тулэгдэн нүүгэрсэн мэт харагдаг. Гэвч бороо их орвол үзсэгэлэнтэй ногоон диваажин болон хувирдаг. Бид зуны эхэн үед тус целеөр аялж байна. Өвөл нэлээд бороо оржээ. Ургамлууд ногоорон харагдах бөгөөд зарим газартай цолийн хөрс зэрлэг цэцүүдээр хучигдсан байх юм.

▲ Бороо орсны дараа хамгийн зэрлэг ургамал хүртэл цөлд тэсэн үлддэг.



► Сонораны цөлд өчүүхэн өвснөөс эхлээд аварга том кактус хүртэл маш олон төрлийн ургамал байдаг.



◀ Энэ Аннагийн соно  
бялзухай саяхан  
үүрэндээ эргэн иржэ.  
Түүний ангаахай өврийт нь өчүүхэн  
жижиг ялаагаар хоолпохыг  
хүлээж байлаа.

Бяцхан шувуу гэнэт  
сум адил билэн  
үрүү шуугийн  
нисеч ирснээ  
бидний дэргэд  
шахуу эргэлдэн  
нислээ. Түүний  
далавчиууд  
харагдахгүй  
шахам маш хурдан  
ձээж байлаа. Соно  
бялзухай цэлрүү  
нисэн одоогоос өмнө  
бидэн үрүү ууртайгаар час  
час хийн дутгарлаа.

Бид түүний ирснэ мол уруу дохеж очин,  
юут хамгаалж байсныг нь олохоор хайв.  
Анхааралтай гэгч нь харснаахаа дараа залзны  
шүлс болон амьтны үсээр барьсан аяганы  
хэлбэртэй өчүүхэн жижиг шувууны үүр  
байхыг олж харв. Соно бялзухайнүүд үүрээ  
засалдаа үсийг хооронд нь наалдуулахын  
тулд залзны этгөн шүлсийг ашигладаг бөгөөд  
үүрээ өнгөлөн далдлахын тулд наач, мөчир  
гадуур нь наалдуулдаг аж.

Үүрэн дотор нь хоёр бяцхан зүйл, мен  
хачирхалтай хоёр ангаахай байлаа. Бид өлмий  
дээрээ зогсож тэднийг өнгийн харахад тэд  
үүрээсээ толгойгоо цухуйлган, эхийгээ хоол  
авчирч огч байгаа гэж бодсон мэт бидэн үрүү  
час час хийж дуугарав.

Бид арагшаа хэд алхаж, чимээгүй хүлээлээ.  
Хэдэн минутын дараа эх нь хошуугаараа  
дүүрэн жижиг ялаатай бушан ирээд,  
ангаахайнүүдээ оглөө. Тэр урт нарийхан  
хошуугаа тэдний хоолой уруу гүн шургуулсан  
хоолыг нь оглөө. Хеөх! Тэднийг өвтгөж  
байгаа юм шиг харагдаж байна гээч. Гэвч  
ангаахайнүүд үүнд нь баярлаж байгаа  
бололтой. Дахинад ч идэхийг хүсч байлаа.



# "Хаздаг" Ургамлууд




Сонорын цөлийн ургамлын излээд хувийг кактус эзэлдэг. Тэд энэ хатуу ширүүн нөхцөлд ургах арга замаа олчихсон байдаг нь гайхалтай. Тэдээр ургамлууд ган гачгийг тэсвэрлж үлэхийн тулд маш их хэмжээний усыг өөртөө хадгалж байдаг. Аргар бүрхүүл нь өргөст тор шиг хунирсан байх ба энэ нь тээнд сунаж томрон, бороо ороход өөрсдийгээ усаар дүүргэх бололцоо олгодог. Мен здэээр ургамлууд амьтдад идуулэхээс хамгаалсан өргестэй байдаг:

◀ Чолла кактус олон хэсгүүдээс тогтох ба энэ нь яг л их биенээсээ сугаран унах гэж байгаа мэт бөгөөд арагш нь самнавал чамайг хаттах болно.

Чолла кактусны өргөс хамгийн хүрц үзүүртэй нь бөгөөд өргөсөн дээрээ өчүүхэн жижиг үснүүдтэй учир биенд наалддаг. Би чоллан дундуур явж байгаад санамсаргүй өргөснийх нь үзүүрийг хөдөлгөхчөв. Гэтэл хүрснээ ч мэдээгүй байхад нэг хэсэг кактус миний гаранд наалдчихав. Маш их өвдөж байсан ба ногое гараараа авч хаях гэсэн боловч бас л наалдчих гээд байв. Би халаасны хуттаа гарган арай хийж нэг юм тэднийг салгав. Ёох! Энэ кактусыг лав үсэрдэг чолла гэдэг байх. Учир нь тэд үсэрч ирээд наадад наалдсан шүү дээ!

◀ Чолла кактус цеп дундуур "аялж", өөрсдийгээ бусад амьтад буюу тэдний хөлд наалдуулан шинэ газар нутагт очин ургагдаж.





▲ Торхон кактус бүрхүүлэн дэх хумснуудыхаа тусламжтайгаар бороо ороход сунаж томордог.

Магадгүй та нар угсүй болбол кактусыг зүсээд доторх усыг нь ууж болно гэж бодож байж магадгүй юм. Гэвч ихэнх кактусны хувьд энэ нь боломжгүй бөгөөд уусан хүн өвдөх магадлалтай. Харин ганцхан торхон кактус уухал аюулгүй усыг өөртөө агуулж байдал. Азаар торхон кактус нь түгээмэл бөгөөд танихад ч амархан байдал. Хэрвээ энэ кактусны усыг уухыг хүсвэл өргөсийт нь экзээд харах хэрэгтэй!

► Улаан дарсны аяга нэртэй энэ кактусанд том цэцэг бий. Энэ цэцэг нь веертэй бал хуримтлуулдаг тул зөвгийнүүд ихээр ирж суудаг.



Өргөст лийр том өргөсүүдээ тойрсон маш жижигхэн өргөсүүдтэй байдал. Тэр жижиг өргөсүүд энгийн нүдээр бараг харагдахгүй. Харин арьсанд наалдвал өдрийн турш загатнуулна. Хэрвээ цэлийн газрын гадрагыг самардаж үзвэл кактусны орооцолдсон олон үндэс гарч ириз. Цөлд бороо орлоо гэж болоход хөрсний чийгийн хэдхэн сантиметрийн дээд хэсгийг л ногодог тул кактусны үндэс тийм ч гүнд биш байдал. Тэрний оронд үндэснүүд нь маш том талбайг эзлэн оршдог. Ганц чолла кактусны нэг метр хүрэхгүй урт үндэс я гэхэд бүхэл бүтэн тениссний талбайтай тэнцэхээр газрыг бурхдэг гээч!

*Улайссан хилэнцэт  
хорхой ба*

## **Хоржигнуур Могой**

**Ц**өлийн ихэнх амьтад өдрийн ид халуунаас нуутдан амь гардаг. Нар жарган арай сэргүүн болоход цэл сэргэж, майхны орчмоор ургамал ногооны доогуур оньсого мэг шаржигнах чимээ сонсгодон. Бид ямар нэг амьтан олж харахаар шөнийн аялалд гарлаа.

Зарим хилэнцэт хорхой дээр ягаан түяа тусгавал улайран гэрэлтдэг. Бид тэднийг хайж олохоор тусгай хэт ягаан түкэнэ гар чийдэн авч явлаа. Гар чийднэгээ асаахад хилэнцэт хорхойнууд яг ягазар дээр байрлуулсан одод мэг гэрэлтэн харагдаж байлаа. Тэд жижиг шавж агаахаар гарчээ. Тэд том чимхүүрээрээ шавжaa барьж аваад сүүлээрээ хатгадаг.



Шөнө алхаж явахдаа болгоомжтой байх хэрэгтэй. Энэ бол хоржигнуурт могойнүүдүү анд гардаг үе нь юм. Тэд өөрсдийгээ маш сайн өнгөлөн далдалдаг бегеед хор нь үхэлд ч хүргэдэг. Хоржигнуур могой жижиг хулгана иддэг. Тэд хулгани зам дээр отон, гарч ирэхээр нь тэдэн үрүү довтлон зүү хэлбэртэй шүднийхээ нүхээр хордуузнаа.

◀ Хамар дээрх нүүрээрээ идэшнийхээ биенийн халууныг таних чадвартай байдаг.





Могой үхэж байгаа хулганы үлдээсэн үнэрээр нь даган явж түүнийгээ залгидаг. Могоинууд идшээ зажилж чадлагтуй бөгөөд тэд агнасан зүйлээ бүхлээр нь залгидаг. Зарим үед хулгананаа залгихын тулд эрүүгээ хүртэл мулталдаг. Нэг хулгана гурав хүртэлх хоногийн өл даана. Хэрвээ могой хулгана идсэн байвал биен дотор нь хулгана төвийн харагдана.

► Зарим хилэнцэт хорхой хэт ягаан тuyaанд үнэхээр гайхалтайгаар гэрэлтэн харагдана.



◀ Бутэн сартай шене цеп бүхэлдээ гэрэлтэн харагддаг. Заримдаа сарны гэрэл сүүдэр гаргахад хангалттай гэрэлтэй.

▲ Шенийн турш цэцэг дамжин, шавж хеөх сарьсан баатваахайн далаачны чимээ сонсогддог.

Сонораны цэлд дэлхийн бусад газруудад байдгаас ч олон төрлийн хоржигнуур могойнууд бий. Хамгийн түгээмэл нь дээд тал нь хоёр метр урт болдог хүний хөл шиг бүдүүн, "барууны алмазан нуруутай"



хоржигнуур могой юм. Өвлийн хүйтэн саруудад могой агуй дотор ичдэг. Нэг агуид 30 гаруй хоржигнуур могой нэг дор унтаж байхыг ч харж болно. Зарим үед яст мэлхий, сүрэг харх ч хамт унтаж харагдана.



*Өөр Нэг Ертөнцөөр*

## Аялсан нь

**М**аргааш өглөө нь бид эртлэн бослоо. Гутлаа юмсахийнхөө ёмне очигдор шонө хaa сайгүй явж байсан хилэнцэгт хорхой гутал дотор байгаа эсэхийг шалгалаа. Түргэн зуурын өглөөны цайны дараа тус нутгийн газрын зургийг гаргалаа. Өноөдөр бид ойролцоо хавцлаар аялахаар шийдэлзэ. Эн аялал өдрийн ихэнхийг авах шинжтэй байсан болохоор бид өдрийн холлоо боон, үүргэвчиндээ нэлээд олон сав ус хийн авч явлаа.



◀ Зарим газраа хавцал таван ширхэг хоёр давхар автобус дээр дээрээс нь давхарласантай тэнцэх тийм өндер байлаа.

Хавцлын хананууд маш эгц учраас доошоо буухад хүндрэлтэй байлаа. Бид хавцлын ирмэгээр нэлээд явж байгаад хэдэн зуун жилийн өмнө Америкийн индианчуудын сийлсэн хадны зураг бүхий ханыг олж харлаа. Энэ нь хавцал уруу уруудаход аюулгүй гэсэн тэмдэг болох газар байлаа. Бид удаан болгоомжтой доош уруудлаа.

Эцэст нь ёроолд нь хүрлээ. Хавцал дотор сэргүүхэн, сүүдэртэй бөгөөд дээр байгаа халуун цэл шиг санагдахгүй байв. Хамгийн сүүлийн борооноос үлдсэн хэд хэдэн цөөрөм байх юм. Бид зэрлэг чонын хөлийн мөртэй тааралдлаа. Магадгүй тэр ус хайхаар энд ирсэн байх.

▼ Энэ зэрлэг чоно шиг амьтад хавцал уруу ус хайхаар бууж ирдэг.



◀ Энэ хэдэн бээр хавцал үргэлжлэх учир төөрч мэдхүү юм. Дээшээ гарахдаа маш болгоомжтой байх хэрэгтэй.



▲ Энэ хадны зургийг Америкийн индианчууд хавцал уруу буухад аюулгүй гэсний тэмдэг болгон сийлжээ.

Хавцал зарим хэсэгтээ маш нарийхан, хоёр талд нь хүрч болмоор. Харин заримдаа хавцал дэлгэгдэн, сүүдэрт нь том том модод ургасан байх юм. Биднийг илгэн нарийхан хавцал дундуур явж байхад хавцлын хоёр талд тээгээн унисан аварга том мод дээгүүр хөндөлсөн харагдлаа. Хүчтэй бороо орвол далайн түлхолт мэт их ус хад чулуу, мөддүү хамт хавцал уруу урсан буудаг.

Бид бие үрүүгээ харан, энд их удаж болохгүй ухаарлаа. Үер буувал энд их аюултай. Бид даруй бууж, ирсэн газраараа авиран гарлаа. Энэ үед тэнгэр бараан үүлээр бүрхэж, ширүүн бороо орох гэж байгаа мэт харагдаж байлаа. Хавцлаас хурдан гарах цаг болжээ!

# Цөлийн Галын Наадам

► Алсаас ширүүн бороо ирж явааг бид ирэхээс нь өмнө олж харлаа.

▼ Зуны саруудад аянга маш хурдан үүсдэг.  
Тэнгэр ийнхүү харанхуйлж эхэлбэл хоргodoх газар хайх цаг болжээ гэсэн үг.





▲ Сонораны цэл бол цахилгаан цахихыг харж болох хамгийн тохиромжтой газруудын ног юм. Учир нь цэлийн агаар маш халуун бөгөөд үүл газраас их өндөрт орших тул маш урт цахилгаанууд үүсдэг.

Бид хавцлаас гаран цэл үрүү бушлаа. Тэнд аймшигт үүлиүүд хурж байлаа. Маш их хэмжээний бороо орж болох байв. Азаар бид хавцлаас амжин гарлаа. Аяны хөнжил, майхан доторх тоноглол хэрэгслээ авахаар яавчилан алхлаа. Бидний яaran буцааж байхад салхи нэмэгдэж цэлийн хуурай хөрсөн дээр борооны анхны том гэгчийн дусал буув. Цэл дэх зуны эхний ширүүн бороо амьсгаа авахын завдалгүй ширүүн ордог.

Өдрийн турш үүлиүүд давхралдан боөгнөрч, цэлийн газрын гадаргаас дээшлэх халуун агаараас энерги хуримтлуулна. Аажимдаа үүлиүүд харлан доошиллоо. Хэдхэн минут цэл амьсгаагаа дарах мэт нам гүм боллоо. Гээзт салхи гарч бороо цутгав. Яг л дэлхийн төгсгөл шиг санагдаж байлаа. Аварга том сагуаро кактус резинээр хийсэн мэт ганхаж, наач шороо агаарт хүйлран ниснэ.

Эргэн тойрон тэнгэрт цахилгаан цахиж байлаа. Аадар борооны дуу айлас төрүүлж, бид майхан дотроо шахцалдан хэвтэв. Бороонд норохгүй сайхан байлаа. Бид даруй хуурай хувцас өмсч, дуулаацааж эхлэв. Цахилгаан байнга цахилах бүрд бид аянганы дуу гарахаас өмнөх секундийг тоолж эхлэв. Ингэвэл цахилгаан хэр ойр байгааг мэдэх болно.

▼ Цэлд ийм зүйл тохиолддог гэдэгт та нар итгэхгүй байж магадгүй. Гэхдээ өвлийн цасан шуурга цаст кактусуудыг цасаар бүрхдэг. Гэвч хэдхэн цагийн дараа л тэр нь хайлдаг.



## Хивс

Дараа өглөө нь бид зэрлэг чоногуудын улианаар үүр түяараахас уртаж сэрлээ. Газрын гадарга борооны усыг тэр дор нь шингэн авч аль хэдийн хатан, агаар бороогоор угаагдсан мэт цэвэр тунгалаг болсон байлаа.

► Мексикийн алтан намуу цэцэг борооны дараа хэдэн долоо хоногын дотор урган, цэцэглэж, бас үхчихдэг байна. Гэвч үр нь хөрсөн доор хэдэн жилийн турш байж чаддаг юм.

Борооны дараа ургамал хурдан ургаж энэ цол үзэхээр онцгой харагддаг. Энэ жил бороо ихтэй байгаа бөгөөд зарим газраа зэрлэг цэцэгсэг хивс адил ургасан байна. Мянга мянган үзэсгэлэнтэй, гобомсог ургамал ихэнхдээ нүшгэн, хүрэхийн аргагүй халуун байдаг газарт цоройн ургасан байлаа.

Шавжнууд хaa саагүй дүнгэнэлдэнэ. Тэд байдал хурдаараа цэцгийн тоос, бал цутглуулан завгүй дэрвэн ниснэ. Хэдэн долоо хоногийн дараа цол дахиад л хуурайшиж амьдралгүй болно. Тэгээд магадгүй олон жилийн турш бороо орохгүй байх. Эзээр ургамлуудын боловсруулсан бяцхан дусал адил үрнүүд дараагийн





удаа бороо орохыг хүлээн, газрын хөрсөн дор хэдэн жилийн турш амьдарна. Магадгүй энэ нь маш удаан хугацааны хүлээлт байх. Сонораны цөлд ийм их устай бороо 10 жилд ганц л тохиолддог аж.

◀ Борооны дараа хэдэн долоо хоногийн дотор энэ бүхэн эргээд л цөл болно гэдэгт итгэхд ч бэрх юм.

▼ Итгээн ч бай үгүй ч бай зэгээр ягаан цэцэгсийн нахмаг хуурвал үнэхээр сайхан амттай болно шүү!

Энд төрөл бүрийн хэлбэр, хэмжээ, онго бүхий цэцэгс байна. Зарим нь зөгий болон бусад шавижнууд суухад хялбар, таваг шиг хэлбэртэй байна. Негеө нэг хэсэг нь зөвхөн урт хошууга гүн шургуулан, балаар хооллодог соно бялзуухайн хэлэнд тохирсон бүрээ хэлбэртэй байх юм.

Цэцэгсийн хувьд цөл нь бороо орсны дараа хэдхэн долоо хоногийн турш нэг дор чихэлдэн амь тэмцэн ургах тийм л хүнд бэрх амьдрал юм. Кактус мэтийн ургамлууд бол эсрэгээр, олон жилийн турш удаан ургах ба бороо орохгүй уdsаныг тэсвэрлэхэд найдвартай байдаг.

Цолийн зарим ургамал зуны халуунд хатаж үхсэн мэт харагдах ч амьд хэрээрээ л байдаг. Хэрээ байгалийн ширүүн нөхцөлд тээсхээ боливол навчаа унаган, дараагийн бороо орохыг

хүлээн  
орно.





## Өргөсгүй Гайхлууд

Цэлд амьтан амьдрах боломжгүй мэт харагддаг. Гэвч ургамлын иш, хад чулууны дундуур ойртон ажиглаал хачирхалтай амьдралтай, хачин жигтэй үет хөлтнүүдийн сртенцгэй учирна.

► Энэ аварга том цеплийн жаран хөлт 20 см хүртэл урт байдаг. Энэ бол аймшигт махчин амьтан бөгөөд хулгана шиг том амьтныг ч алах чадвартай.

Бидний "мөлхөгч" гэж бодож байсан аалз, хилэнцэт хорхой, жаран хөлтүүд бол үнэндээ үет хөлтнүүд юм. Тэд биес бүрхсэн "экзо-араг яс" гэж нэрлэгддэг жижигхэн хуяг адил хатуу бүрхүүлтэй байдаг. Зөгий болон зарим төрлийн хорхойнууд иисдэг байхад аалз, хилэнцэт хорхой мэтийн үет хөлтнүүд үсэрч зөвлөл алхаж явдаг. Нас гүйцсэн хорхой зургаан хөлтэй байхад зарим зүйлийн жаран хөлт зуун холтэй ч байх нь бий. Ихэнх үет хөлтнүүд ургамал иддэг байхад зарим нь

бусад үет хөлтнүүдээс барьж иддэг.



▼ Ташууран хилэнцэт хорхой нь мөрэгчдийн сүл орхисон нүхэнд амьдардаг. Тэд шох үзүүртэй, хүчирхэг урд хөлөөрөө бусад үet хөлтийг цоо хатган бяцалж иддэг.



◀ Энэ нарны аалз царцаа барьжээ. Биетэй нь харцуулбал энэ аалзны эрүү нь бусад амьтдынхаас хамгийн том нь бөгөөд хүчтэй нь юм.

Үet хөлтиүүд цөлд амьдрахад гайхалтай сайн зохицсон байдаг. Зарим нь маш бага хоол, үнэндээ бараг усгүйгээр шахам хэдэн сар ч амьдрах чадвартай. Учир нь үet хөлтиүүд маш жижигхэн учраас өдрийн эд халуунд хад чулууны завсар нутгиддаг. Тэдний "экзо-араг яс" нь усыг гадагшлуулахгүйгээр тогтоон барьдаг учир сүүн тэжээлтиүүд шиг чийгээ арьсаараа алддагтуй.

Нарны аалз нь Сонораны цөлд тааралдаж болох хамгийн аймаар харагддаг үet хөлтон юм. Энэ амьтад бол жинхэнэ аалз биш боловч яг тэдэнтэй адилхан харагддаг бөгөөд хэрвээ чи нэгийг барьж чадвал том нь л гээд гарын алгатай тэнциэн. Тэд бол махчин амьтан. Жижигхэн ирвэс адил маш хурдтай гүйж очин идшийн барьдааг. Тэд хорхой, аалз, тэр ч байтугай гүрвэлийг хүчирхэг амаараа алж иддэг.

Зуны шене найман хөлтэй целийн үсрхэг амьтад гэтэн явах нь элбэг харагдана. Эр тэмээн аалз амьдралынхаа эхний 10-12 жилийг шүлсээрээ нэхэн үүрэн дотроо түүгээр харгүйгээр тэнүүчлэн яваа идэшнийхэс хойноос хөөцөлдөн онгургуулдаг. Дараа нь тэр хөгшрөөд ирэхээрээ үүрнээсээ гарч эм аалзаа хайн целеөр аялдаг.

Энэ цөлд тэмээн аалз мэтийн аймаар амьтдад дайсан байхгүй мэт санагдана. Гэвч түүнийг барьж иддэг "тэмээн аалзны харцага" гэж нэрлэгддэг шар зогийний нэгэн төрөл бий. Энэ том шар зогийнүүд тэмээн аалзны үүрийг хайн, целеөр нисэх үедээ очуухэн жижиг нисдэг тэрэгний адил дуу гаргадаг. Хэрвээ тэд үүр олж харвал аалзуудыг үүрнээс нь гаргахыг оролддог. Тэгээд тэд аалзыг хошуугаараа наалдуулдаг. Дараа нь яг л аймшигийн киноны үзэгдэл шиг ухаан алдсан аалзыг үүрнээс нь гарган биен дээр нь ондогледог. Шар зогийний авгалдай ондогнеөсөө гарч ирээд найман хөлтэй хоолоо зооглоно.

▼ Энэ аварга том шар зэгий сэрэмжгүй нэгэн тэмээн аалзны хувьд маш том аюул юм.



# Цөлийн Манаач

Сонорыны цэлд хамгийн ихээр ялгаран харагдах ургамал бол сагуаро кактус юм. Энэ гайхалтай ургамал цэлийн амьдралд амин чухал үүрэг гүйцэтгэдэй. Сагуаронууд том ургамалууд дотор ургадаг. Тэд гурван давхар байшинтай тэнцүү өндөр, хоёр том машин шинг хүнд болдог ба 200 жил хүртэл насалдаг.

◀ Сагуаро кактус цэгнээс томгуй өнчүүжэн жижиг үрнээс ургадаг. Хэдэн зуун жилийн дараа гурван давхар байшин шиг өндөр болно. Сагуаронууд Сонорын цэлд элбэг тохиолдох бөгөөд зарим газарт нь маш олон тооны кактусны ой хүртэл байдаг.

Хатuu ширүүн цэлийн уур амьсгалд тэсвэрлэн ургадаг мод олон байдагтүй. Тийм учраас ихэнх шувуунууд халтуун газрын гадарга, махчин амьтдаас өндгөө хамгаалахын тулд сагуаронууд дээр үүрээ засдаг.

◀ Зундаа Сагуаро дээр наалдамхай улаан жимс ургадаг нь амьтдад их таалагддаг. Энэ хоёр урт эвэрт эр цох хорхой эм жимсээр хөөлплоод зогсохгүй энэ цох хорхойнудыг хүлээж байна. Энэ төрлийн цох хорхой сагуарогийн жимсийг уулзах газраа болгон ашиглдаг.



Хавартаа сагуаро кактусны мөчрийн үзүүрүүд нь том цагаан, шар цэцгүүдээр хүчинддаг. Сарьсан багваахай, шувуу болон бусад шавжнууд цэцгэн дээрх зөгийн балаар нь хооллохоор ирдэг. Энэ нь сагуарогийн хамгийн их хүсэн хүлээдэг зүйл юм. Учир нь эдгээр амьтад бал хайхаар цэцгэг үрүү шурган ороход шар цэцгийн тоос агуулсан эр дохиураа арагш нь болгодог.

Энэ цэцгийн тоос нь тэдгээр амьтдал наалдан, дараагийн очих цэцгэнд үр тогтохоор явна. Сагуаро цэцэлих үед толгой дээрээ шар будагтай мэт харагдах шувуунууд цэцгийн тоос наалдуулсан кактуснаас нөгөө кактус уруу нисэн явах нь элбэг тохиолдноно.

▼ Хавар энэ том цагаан цэцгүүд сагуарогийн мөчруүдийн үзүүр дээр ургана. Цэцгэн дотор нь шар тоос харагдана.

► Энэ анаахай шар шувуу Хөлэ тоншуулын аварга том сагуаро дээр гаргасан нүхэн дотор үүрээ засссан байна.

Зуны дунд сард температур нэмэгдэж хоол хүнс ховордож эхлэх үед сагуаро кактус целийг хоолоор хангадаг. Энэ үед тэд жимсээ боловсруулдаг. Кактусны мөчрийн үзүүрүүд цэцгэлж эхлээд том улаан амтат жимснүүд гарч ирдэг. Сарьсан багваахайнаас эхлээд цох хорхой хүргэлх цэлийн бүх амьтад энэ жимсэнд дуртай. Доод талын мөчруүд дэж жимс нь гүзээлгэнд чанамал шиг амтагдах бөгөөд хэлийг улаан болгодог.





## Эвэртэй Гүрвэл ба Ургац Хураагч Шоргоолж

Бид өглөөний цайгаа ууж байхдаа  
өнгөрсөн шенийн аадар бороо  
ойролцоо сагуарогын зарим  
жимсийг унагасан байхыг харлаа. Энэ  
салхинд унасан жимсийг ургац хураагч  
шоргоолжууд олж харан үрийг нь аван,  
үүр лүүгээ зөвж байв. Шоргоолжнууд нар  
хэтэрхий их халахаас өмнө амжиж бүх  
үрийг хураах гэж шаргуу ажиллаж байлаа.



▲ Энэ шоргоолж жимсэн дотроос үрийг нь  
сугалан авах гэж ноцопдох байна. Аварга том  
наалдамхай амттан дотроос хел бөмбөгий  
шүдээрээ сугалахыг оропдох байна гээд төсөөл  
доо!

Миний нүдний буланд нэгэн зүйл үзэгдэв.  
Яг л чулуу хөдлөх шиг харагдлаа. Бид  
ойротж хараад чулуу биш эвэртэй гүрвэл  
 болохыг нь мэдлээ. Энэ гайхмаар бяцхан  
 гүрвэл элс хайрганаас ялгагдахааргүй  
 болтлоо өөрийгөө сайн гэгч нь өнгөлөн  
 далдалжээ. Дээрээс нь харвал бяцхан үлэг  
 гүрвэл шиг байлаа.



◀ Өнгөрсөн шэнийн аадар борооны дараа хэдэн үүл үлдсэн байх ба өглөөний агаар сэруун тунгалаг байна.

Зарим төрлийн эвэртэй гүрвэл шоргоолжноос өөр юу ч илдэгтүү бөгөөд нялцанхай хэлээрээ залигдаг. Тэд эргэн тойрон ухасхийн хөдөлж, хэлээ түргэн түргэн булталзуулан шоргоолжийг барьж иддэг. Шоргоолжнууд эсэргүүцхийг оролдовч хүчирхэг ам нь шоргоолж илдэг хуягт машины хувыд юу ч болсонгүй. Бид эргэн тойриоо харахад гүрвэлийн унагасан жижигхэн хар зүйл байлаа. Барид авах гэтэл бутарчихдаг. Тэдгээр нь түүний гэдсэнд боловсрогдсон үхсэн шоргоолжны үлдэгдлийн өөр юу ч байгаагүй.

▲ Удаашруулан харвал эвэртэй гүрвэлийн нүднээс цус цацагдаж байгааг харж болно.

▼ Жижигхэн үлэг гүрвэлийг дуурайсан эвэртэй гүрвэл шоргоолж зооголдог. Анхааралтай сайн харах юм бол баатарлагаар тупалдахыг хичээж буй шоргоолжийг харна.



# Хурдан Гүйгч ба Тэнгэрийн Чононууд

